БАТЛАВ.
СЕХ-ны Ажлын албаны
дарга

Д.БАЯНДҮҮРЭН

БАТЛАВ.
Смартлайм ХХК-ийн
захирал

Н.АМГАЛАН

ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2016 оны 03 дугаар сарын 23.-ны өдөр

Дугаар УИХ-07

Улаанбаатар хот

Нэг. ***Нийтлэг үндэслэл***

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг баримтлан энэхүү гэрээг нэг талаас Сонгуулийн Ерөнхий Хороо /цаашид захиалагч гэх/-г төлөөлж Ажлын албаны ахлах референт Ж.Оюунгэрэл, нөгөө талаас Смартлайм ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг төлөөлж захирал Н.Амгалан нар доорх нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны сонгуулийн саналын хуудсыг хадгалах зориулалттай уут нийлүүлэх, хүлээн авахтай холбогдох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. ***Захиалагчийн эрх, үүрэг***

2.1. Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн саналын хуудас хадгалах уутны тоо, хэмжээ, загвар, үзүүлэлтийг 2016 оны 3 дугаар сарын 23-ны дотор гаргаж өгнө.

2.2. Саналын хуудас хадгалах уутыг нийлүүлэх явцад захиалагчийн зүгээс хянах, зөвлөх эрх бүхий хүн ажиллуулна.

2.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүн шаардлагад нийцээгүй тохиолдолд ажил гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг дахин гүйцэтгүүлнэ.

2.4. Барааг чанар, шаардлагын дагуу захиалагч хүлээн авмагц төлбөрийг гэрээнд заасны дагуу саадгүй төлнө.

Гурав. ***Гүйцэтгэгчийн эрх, үүрэг***

3.1.Саналын хуудас хадгалах уутыг 6800 ширхэгийг загварын дагуу нийлүүлж 2016 оны 5 дугаар сарын 23-ны дотор захиалагчид хүлээлгэж өгнө.

3.2. Саналын хуудас хадгалах уутыг хавсралтанд дурдсан загвар, дизайн, хэмжээтэй, өнгө үзэмжтэй, санамж бичигтэй хэвлэж нийлүүлнэ. Тогтоосон загвар, хэмжээ, өнгө, дизайнаас өөрөөр хийсэн, хугацаа хожимдуулсан тохиолдолд өөрийн зардлаар хохирлыг арилгаж хариуцлага хүлээнэ.

3.3. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.4. Чанарын шаардлагад нийцээгүй бараа нийлүүлсэн тохиолдолд тогтоосон хугацаанд нөхөн нийлүүлнэ.

3.5.Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 19 дүгээр хавсралтын дагуу гаргасан мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хорооны цахим хуудас, мэдээллийн самбарт заавал байршуулна.

Дөрөв. ***Төлбөр тооцоо***

4.1. Саналын хуудас хадгалах уут нэг бүрийг 4900 төгрөгийн үнэтэйгээр нийлүүлж Сонгуулийн Ерөнхий Хороонд хүлээлгэж өгсний дараа төлбөрийг Смартлайм ХХК-ийн Голомт банкны 1601431158 тоот дансанд ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ. Регистр: 5261546

№	Төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Саналын хуудас хадгалах уут	6800	4900	33 320 000
Дүн				**33 320 000**
НӨАТ 10%				3 332 000
НИЙТ ДҮН				**36 652 000**

4.2. Нэмэгдсэн өртгийн албан татварыг гүйцэтгэсэн ажлын нийт үнийн дүнгийн 10 хувиар захиалагч тал төлнө.

Тав. ***Бусад зүйл***

5.1. Захиалагчийн буруутай үйлдлээс шалтгаалж загвар, тоо хэмжээг өөрчилсөн зэргээс үүдэн гарах хариуцлагыг захиалагч өөрөө хүлээнэ.

5.2. Хугацаа хожимдуулсан, чанарын гологдол, алдаа гаргасан, загварын дагуу хийгээгүй зэрэг шалтгаанаас учирсан хохирлыг гүйцэтгэгч хариуцна.

5.3. Энэхүү гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

5.4. Маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба эс тохиролцвол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Сонгуулийн ерөнхий хорооны
Ажлын албаны ахлах референт

Ж.ОЮУНГЭРЭЛ

Хаяг: Улаанбаатар-38
Ж.Самбуугийн гудамж-11
ЗГ-ын XI байр
Сонгуулийн ерөнхий хороо
Утас: 51-263386

Смартлайм ХХК-ийн
захирал

Н.АМГАЛАН

Хаяг: БГД, 2 дугаар хороо
Үндсэн хуулийн гудамж
37 дугаар байр 1 тоот
Смартлайм ХХК
Утас: 99096060

Сонгуулийн ерөнхий хорооны
2016 оны худалдан авах ...УИХ-07...дугаар
гэрээний хавсралт

УХА0306

САНАЛЫН ХУУДАС ХАДГАЛАХ УУТ

Материал	-90 микрон зузаантай полиэтилин
Өнгө	-Саарал
Хэмжээ	-өндөр 40 см - өргөн 60 см
Багтаамж	-250-350 саналын хуудас
Нэмэлт	-Гадна хэсэг нэг өнгө бүхий хэвлэлт, дараалсан сери, дугаартай
Нууцлал бүхий наалт	-Дахин салгах, онгойлгох боломжгүй 3 см өргөнтэй зурвас бүхий нэг удаа ашиглах наалт
Үйлдвэрлэх улс	-Гонг Конг
Нийлүүлэх хугацаа	-60 хоног
Тоо хэмжээ	-6800 ширхэг
Нэгжийн үнэ	-4900 төгрөг /НӨАТ ороогүй/

Уутны загвар

Уутны дугаар:

Хорооны лого

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Энэхүү уут нь нэг удаа хэрэглэгдэх бөгөөд уутыг наасан бол дахин ашиглах боломжгүй. Иймд уутанд хийгдэх бичиг баримтыг нягталж хянасны дараа битүүмжилнэ үү.

АШИГЛАХ ЗААВАР

1. Уутанд зөвхөн саналын хуудас хийнэ.
2. Саналын хуудсаа уутанд хийсний дараа уутны амсар дээр байгаа цэнхэр туузыг хуулаад уутны амсрыг нийлүүлж наана.
3. Уутны амсар бүрэн наалдсан эсэхийг шалгана.
4. Ууттай саналын хуудсыг хүлээлгэн өгөхдөө уутны дээд талын тасархай шугамаар тэмдэглэсэн дугаартай хэсгийг авч үлдэн холбогдох бичиг баримтын хамт хадгална.
5. Доорхи хаягийг бүрэн бөглөж хүлээлгэн өгнө.
6. Уутны даацыг хэтрүүлж болохгүй /250-350 ширхэг/

Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр:	
Хэсгийн дугаар	
Саналын хуудасны тоо	
Хүлээлгэн өгсөн хүний нэр	
Хүлээн авсан хүний нэр	
Хүлээлгэн өгсөн огноо	

Уутыг наасны дараа нээхийг хориглоно. Уутны амсар бүрэн наалдсан тохиолдолд онгойлговол уутыг дахин ашиглах боломжгүй болно.

ХАМГААЛАЛТЫН ТУУЗ ХАМГААЛАЛТЫН ТУУЗ ХАМГААЛАЛТЫН ТУУЗ ХАМГААЛАЛТЫН ТУУЗ

СМАРТЛАЙМ

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 19 дүгээр хавсралт

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл

№	Гүйцэтгэгчийн нэр	Тухайн жилд нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээний нэр	Гэрээний дүн	Хэрэгжилтийн явц (өссөн хувиар)	Тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардал (өссөн дүнгээр)	Төсвөөс олгосон санхүүжилт (өссөн дүнгээр)
1	Смартлайм ХХК	Сонгуулийн саналын хуудас хадгалах уут	36 652 000 ₮	100%	28 508 837 ₮	36 652 000 ₮

СМАРТЛАЙМ ХХК УЛААНБААТАР ХОТ 1116215989 №5281546

Смартлайм ХХК-ий захирал
Н.Амгалан